



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/526

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, шийдвэр, зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, Коронавируст халдвар (Ковид-19)-ын дараах нөхөн сэргээх, сэтгэл заслын зөвлөгөө, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр аймгийн Засаг дарга, Баянчандмань, Борнуур сумдын Засаг дарга, Шүрэн Ундарга НҮТББ-ын гүйцэтгэх захирал нарын хооронд байгуулсан гэрээний дагуу сургалтын төлбөрийг гүйцэтгэгч байгууллагад гэрээ, нэхэмжлэх, санхүүгийн бусад баримтыг үндэслэн олгосугай.

2.Сургалтын зардалд шаардагдах 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, шилэн дансанд байршуулж ажиллахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР